

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшиүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалыа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–aas татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2025 оны 04 сарын 23-ны өдрийн 09:00 цагаас 05 сарын 02-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: ochmaa@sbd.gov.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 96967570, 70070112

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт:

Д/Д	Байгууллагын нэр	Нэгжийн нэр	Албан тушаалын		Хариуцах асуудал	Орон тоо	Албан тушаалд тавигдах тусгай шаардлага				
			Ангилал	Нэр			Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	Үр чадвар
1	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар	Хороо	T3-9	1,8,9,10,11,13,16,20 дугаар хорооны Зохион байгууллагч	Хууль тогтоомж, нийслэл дүүргийн бодлого шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, хорооны Засаг даргаас байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх, нутаг дэвсгэрийн ариун цэвэр, тохиижилтыг сайжруулах, нийгмийн дэг журам хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хүн амын мэдээллийн статистик тоо бүртгэлийн сан бүрдүүлэх, хөтлөх, судалгаа гаргах, мэдээ мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээ хүргэх	11	Дээд болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	- эрх зүй /0421/; - менежмент ба удирдахуй /041301 041303/; - хот ба бус нутаг төлөвлөт /073103/; - хүрээлэн буй орчны инженер /073201/; - хүрээлэн буй орчныг хамгаалах технологи /0712/; - хүрээлэн буй орчин судлал /052101, 052102/; - газар зохион байгуулалт /073101/; - нийгмийн шинжлэх ухаан /031/; - боловсролын шинжлэх ухаан /0111/; - багш, мэргэжлийн /0114/; - нийгмийн хамгаалал /092/; - эдийн засаг /0311/.	Мэргэжлийн салбарын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол давуу тал болно.	Мэргэжлээрээ ажилласан бол давуу тал болно.	Дун шинжилгээ хийх; Асуудал шийдвэрлэх; Багаар ажиллах; Бусад.
10	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар	Хороо	T3-9	3,5,11,19 дүгээр хорооны Нийгмийн ажилтан	Нийгмийн хамгаалал, ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, хүүхэд залуучууд, гэр булийн хөгжлийг дэмжих талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, холбогдох хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, судалгаа хийх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хорооны Засаг даргад дэмжлэг үзүүлэх, байгууллага, иргэдийг мэдээллээр хангах, төрийн үйлчилгээ үзүүлэх	4	Дээд болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	- эрх зүй /0421/; - менежмент ба удирдахуй /041301 041303/; - нийгмийн шинжлэх ухаан /031/; - боловсролын шинжлэх ухаан /0111/; - багш, мэргэжлийн /0114/; - нийгмийн хамгаалал /092/; - эдийн засаг /0311/.	Нийгмийн ухааны салбарын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол давуу тал болно.	Мэргэжлээрээ ажилласан бол давуу тал болно.	Дун шинжилгээ хийх Асуудал шийдвэрлэх; Багаар ажиллах; Бусад.

